

Сүхбаатар аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн
3-р улирлын тайлан

2024.10.01

Мэдээллийн ил тод байдлыг хангах, салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах, стандартын хэрэгжилтийн үр дүнг сайжруулах зорилгоор хэлтсийн www.masm.gov.mn/sba болон Сүхбаатар Стандарт, хэмжил зүйн хэлтэс гэсэн цахим хуудсанд салбарын үйл ажиллагаа болон бусад төрлийн 71 төрлийн мэдээ, мэдээлэл, видео, контентийг байршуулсан.

Хэлтсийн хамт олон Булган аймагт зохион байгуулагдсан стандарт, хэмжил зүйн салбарын Улсын зөвлөгөөнд оролцсон.

Хэлтсийн албан хаагчид Төрийн албаны зөвлөл, Стандарт, хэмжил зүйн газар болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан 10 удаагийн танхимын болон цахим сургалтад хамрагдаж мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн.

Төрийн үйлчилгээг иргэдэд сурталчилан таниулах, иргэдийн нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулах зорилго бүхий Найрсаг Баруун-Урт арга хэмжээнд тус хэлтсийн хамт олон оролцож байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажилласан.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Намрын ногоон өдрүүд арга хэмжээний үеэр хүнсний худалдаа эрхлэгчдийн 15 ш электрон жинд MNS OIML R 76-1:2023 Автомат бус жинлэх хэрэгсэл. 1-р хэсэг: Хэмжил зүйн ба техникийн шаардлага-туршилт гэсэн стандартын дагуу шалгалт, баталгаажуулалт хийж гэрчилгээ олгосон. 2 аж ахуй нэгж болон 2 иргэний 40 сорьцонд 65 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийсэн. Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн" номинацид 2024 оны 4-р сард арьсан цүнх, нурууны мастер бүс, өргөлийн уут гэсэн 3 бүтээгдэхүүндээ "Байгууллагын стандарт" нэвтрүүлсэн Чулуун дарь овоо ХХК-ны Баян шарга арьсан эдлэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийг шалгаруулсан. Байгууллагын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор 8 төрлийн 240 ш гарын авлагыг тараасан.

Хэлтсийн хамт олон хуваарьт газрынхаа хогийг цэвэрлэж, зайлуулан холбогдох тайланг Баруун-Урт сумын ЗДТГ-т илгээсэн.

Стандарт, хэмжил зүйн газар, аймгийн ЗДТГ болон бусад холбогдох байгууллагуудруу цаг үеийн холбогдолтой 24 төрлийн мэдээ тайланг илгээсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд 33 ш ирсэн бичиг, 14 ш явсан бичиг, хэлтсийн даргын 3 ш Б тушаал, 8 ш А тушаал байгаа бөгөөд крилл, монгол бичгийг хослуулан хэрэглэж хэвшээд байна. Мөн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа ERP, Able системүүдийг ашиглаж байна.

Хэмжил зүйн лаборатори:

Автомашины жин баталгаажуулах Эрээн толгой ХХК, Хүндийн хэмжүүр ХХК-ний хүсэлтийн дагуу 3 ширхэг автомашины жингийн шалгалт баталгаажуулалтыг хийж гүйцэтгэсэн.

ДБЭХС ТӨХК-ны Сүхбаатар салбартай байгуулсан хэмжих хэрэгсэл баталгаажуулалт хийх гэрээний дагуу Дарьганга, Онгон, Наран сумдын айл өрх, аж ахуй нэгж байгууллагын 1 ба 3 фазын цахилгаан тоолуурын ээлжит шалгалт баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Баталагаажуулалтаар 1 фазын 2223, 3 фазын 68 ширхэг тоолуурт гэрчилгээ олгосон.

Намрын ногоон өдрүүд арга хэмжээний хүрээнд Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын техникчийн хамт худалдаа үйлдвэрлэл эрхлэгчдийн 15 ширхэг хуалдааны жинд шалгалт баталгаажуулалт хийж ажилласан.

Стандарт, хэмжил зүйн газар сар бүрийн баталгаажуулалтын статистик мэдээг хүргүүлсэн.

Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг хэлтсийн Хэмжил зүйн лабораторид MNS/ISO/IEC 17025-2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу үнэлгээ хийж, Стандарт, хэмжил зүйн газрын Шалгалт тохируулгын хэлтэст өөрийн лабораторийн итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг боловсруулан хүргүүлэх зөвлөмж өгсөн. Уг зөвлөмжийн дагуу итгэмжлэлийн хүрээг шинэчлэн боловсруулж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Сорилтын лаборатори:

Тайлант хугацаанд 109 аж ахуй нэгж, иргэний хүсэлт болон улсын байцаагчаас ирүүлсэн дээжинд нийт 394 сорьцонд 1195 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж ажиллалаа. Үүнээс нян судлалын шинжилгээ 198 сорьцонд 347 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийснээс шаардлага хангаагүй 24 сорьц, химийн шинжилгээ 184 сорьцонд 836 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийснээс шаардлага хангаагүй 46 сорьц, ургамал хорио цээрийн шинжилгээ 12 сорьцонд 12 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс шаардлага хангаагүй сорьц байхгүй.

Боловсролын байгууллагын өмнөх урьдчилан сэргийлэх улсын байцаагчийн хяналт шалгалтын 53 аж ахуй нэгжийн 108 дээжинд сорилт шинжилгээ хийж ажилласан байна.

Намрын ногоон өдрүүд арга хэмжээний хүрээнд 2 аж ахуй нэгж, 2 иргэний 40 сорьцонд 65 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийж ажилласан.

Стандарт, хэмжил зүйн газарлуу сар бүрийн баталгаажуулалтын статистик мэдээг хүргүүлэн ажиллаж байна.

Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг хэлтсийн лабораторид MNS/ISO/IEC 17025-2018 “ Сорилтын болон шалгалт

тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартын дагуу үнэлгээ хийж ажилласан.

Стандартын салбар сан:

5 аж ахуй нэгж, байгууллагад 12 төрлийн 14 ш стандартаар үйлчилсэн. Найрсаг Баруун-Урт арга хэмжээний үеэр Стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн" номинацид 2024 оны 4-р сард арьсан цүнх, нурууны мастер бүс, өргөлийн уут гэсэн 3 бүтээгдэхүүндээ "Байгууллагын стандарт" нэвтрүүлсэн Чулуун дарь овоо ХХК-ны Баян шарга арьсан эдлэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийг шалгаруулсан.

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалт:

14 аж ахуй нэгжээс Тохирлын гэрчилгээ сунгах хүсэлт хүлээн авсан. 2 аж ахуй нэгжид 48 ш экспортын гэрчилгээ олгосон.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН

СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ, СТАНДАРТЫН САЛБАР САН ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХЖАРГАЛ